



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 онь 05 сарын 14 өдөр

Дугаар А/311

Номгон

Уурын зууханд усан шүүлтүүрийн туршилт
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “а” заалт, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн төвд дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн уурын зууханд усан шүүлтүүрийг туршилтаар хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхжаргал -Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүн

Нарийн бичгийн дарга Ц.Дорж –“Чандмань Баянхонгор” ХК-ний нягтлан бодогч

Гишүүд: М.Мөнхбат –Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Д.Норовринчин – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Уламбаяр –“Баянхонгор эрчим хүч” ЦТХХК-ний гүйцэтгэх захирал

Ө.Хандармаа - Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын мэргэжилтэн

М.Төмөрчөдөр - Онцгой байдлын газрын Галын улсын байцаагч

Д.Ганбаатар- Би-Эйч-Энд-Ди ХХК-ний захирал

П.Рэнцэнпэлжээ- “RMB” ХХК-ний захирал

2.Баянхонгор аймгийн төвд дулаанаар хангагч “Эх бүрдэн” ХХК, “Зүүн шанд” ХХК, “Чандмань Баянхонгор” ХК, “Рашаант хайрхан” ХХК, “RMB” ХХК, “Хөвших од” ХХК, “Марал гүн” ХХК-ний удирдлагууд туршилтаар хийгдэх усан шүүлтүүрийн зардлыг тэнцүү хуваан гаргаж, ажлын хэсгийг ажиллах нөхцөл боломжоор хангасугай.

621010793


2.

3. Усан шүүлтүүрийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор бэлэн болгож, суурилуулж туршилтын ажлыг эхлүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхжаргал), "Эх бүрдэн" ХХК-ний гүйцэтгэх захирал (Б.Давгабазар) нарт үүрэг болгосугай.

4. Дээрх аж ахуй нэгж байгууллагаас гаргасан зардлыг 2021 онд багтааж олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Дэд бүтэц, хөдөө аж ахуй хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН